


МӨНГӨНИЙ ТОЙМ

(2016 оны 6 дугаар сар)

Зураг 1.М2, М1, Нийт зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2015	2016					
	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар
М2 мөнгө, тэрбум ₮	10,050.2	9,850.8	10,015.0	10,113.7	10,518.7	10,659.5	11,188.2
сарын өөрчлөлт, %	2.5	-2.0	1.7	1.0	4.0	1.3	5.0
жилийн өөрчлөлт, %	-5.5	-4.5	-2.1	2.1	8.4	8.3	11.4
Бусад хадгаламж, тэрбум ₮	8,364.8	8,242.7	8,492.0	8,530.0	8,835.2	8,916.5	9,206.8
сарын өөрчлөлт, %	1.4	-1.5	3.0	0.4	3.6	0.9	3.3
жилийн өөрчлөлт, %	-5.2	-5.6	-1.8	0.9	7.4	9.3	9.9
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮	706.7	713.8	655.5	658.6	745.1	788.3	839.2
сарын өөрчлөлт, %	-0.5	1.0	-8.2	0.5	13.1	5.8	6.5
жилийн өөрчлөлт, %	-12.7	-2.5	-15.5	-6.3	1.4	-0.7	11.0
Нөөц мөнгө, ₮	2,459.6	2,310.7	2,308.4	2,360.7	2,987.8	3,204.7	3,526.1
сарын өөрчлөлт, %	17.9	-6.1	-0.1	2.3	26.6	7.3	10.0
жилийн өөрчлөлт, %	-28.2	-19.2	-16.0	-4.4	35.5	32.9	49.9
Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	17,932.8	18,074.8	18,150.2	18,430.3	18,309.0	18,112.8	18,429.5
сарын өөрчлөлт, %	0.5	0.8	0.4	1.5	-0.7	-1.1	1.7
жилийн өөрчлөлт, %	10.9	8.9	11.1	11.5	7.3	6.0	8.2
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	11,695.8	11,783.0	11,628.2	11,827.5	11,629.3	11,437.6	12,018.0
сарын өөрчлөлт, %	-1.6	0.7	-1.3	1.7	-1.7	-1.6	5.1
жилийн өөрчлөлт, %	-6.5	-2.5	-4.5	-3.6	-5.4	-6.1	0.6
Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар	7.44	7.59	7.84	8.18	9.23	9.29	8.62
Чанаргүй зээл/Хадгаламжийн байгууллагуудын зээл, хувиар (Хадгаламж, Зоос банкныг хүү	5.53	5.69	5.91	6.30	7.35	7.38	6.81
Хадгаламжийн ЖДХ	13.3	13.5	13.5	13.3	13.4	13.2	13.3
Зээлийн ЖДХ*	19.1	19.7	20.1	19.7	20.0	19.1	19.1
Монголбанкны УТХ зээлийг оруулсан ЖДХ*	18.3	19.1	19.1	17.9	17.5	17.2	16.9
Ипотекийн зээлийн ЖДХ	8.8	10.0	9.2	8.8	8.2	8.3	8.3
ТБҮЦ-ны ЖДХ	13.0	12.6	12.0	12.0	12.0	10.6	10.5
Бодлогын хүү	13.0	12.0	12.0	12.0	12.0	10.5	10.5
БХЗ-ын ЖДХ	11.8	11.8	11.4	12.6	12.7	12.3	11.3
Инфляци							
Улаанбаатар хотын инфляци							
сарын	-0.2	0.4	0.8	0.3	1.5	0.1	-0.5
оны эхнээс	1.1	0.4	1.2	1.5	3.1	3.2	2.7
жилийн	1.1	1.0	1.6	1.1	1.9	1.8	1.2
Суурь инфляци							
сарын	-0.1	-0.4	-0.4	-0.4	0.1	-0.2	-0.1
оны эхнээс	4.8	-0.4	-0.7	-1.1	-1.0	-1.2	-1.2
жилийн	4.8	4.0	3.5	3.1	3.2	3.1	3.0
Улсын инфляци							
сарын	-0.2	0.5	0.7	0.5	1.4	0.1	-0.3
оны эхнээс	1.9	0.5	1.2	1.7	3.1	3.3	2.9
жилийн	1.9	1.7	2.0	1.7	2.1	1.8	1.6


* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 5.0 хувь, оны эхнээс 11.3 хувь, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өсч 11188.2 тэрбум төгрөг болжээ.

Мөнгөний нийлүүлэлтийн 50.3 хувийг төгрөгийн хадгаламж, 20.4 хувийг гадаад валютын хадгаламж, 12.7 хувийг төгрөгийн харилцах, 11.6 хувийг гадаад валютын харилцах, 5.0 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.


Зураг 2. M2, M1, Бусад хадгаламжийн жилийн өсөлт



Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөний жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сарынхаас 30 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 10.8 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 10.7 нэгж хувиар өссөн бол гадаад валютын хадгаламжийнх 1.5 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 0.8 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн харилцах 197.6 тэрбум, гадаад валютын харилцах 149.2 тэрбум, гадаад валютын хадгаламж 84.8 тэрбум, төгрөгийн хадгаламж 56.3 тэрбум, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 40.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 3. Нийт мөнгөний жилийн өсөлтийн задаргаа




Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өссөний 3.4 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.6 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 2.3 нэгж хувийг гадаад валютын харилцах, 1.9 нэгж хувийг төгрөгийн харилцах, 1.3 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна.

Хадгаламж


Нийт хадгаламж өмнөх сараас 1.8 хувь буюу 141.1 тэрбум төгрөгөөр өсч 7914.1 тэрбум төгрөг болов.

Зураг 4. Хадагаламж, түүний жилийн өсөлтийн задаргаа




Иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 1.6 хувь буюу 73 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 17 хувь буюу 693.3 тэрбум төгрөгөөр өсч 4768.2 тэрбум төгрөгт хүрчээ. Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 1.9 хувь буюу 16.6 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 29.1 хувь буюу 354.2 тэрбум төгрөгөөр буурч 864.1 тэрбум төгрөг болжээ.

Зураг 5. Төгрөгийн хадгаламж



Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 3.9 хувь буюу 84.8 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 13.0 хувь буюу 263 тэрбум төгрөгөөр өсч 2281.8 тэрбум төгрөг болжээ.

Зураг 6. Гадаад валютын хадгаламж




Нийт хадгаламжийн 71.2 хувь нь төгрөгийн, 28.8 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний нийлүүлэлтийн 12.7 хувийг эзэлж буй төгрөгийн харилцах өмнөх сараас 16.2 хувь буюу 197.6 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 15.1 хувь буюу 185.9 тэрбум төгрөгөөр өсч 1419.6 тэрбум төгрөг болсон бол 11.6 хувийг эзэлж буй валютын харилцах өмнөх сараас 13 хувь буюу 149.2 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 21.4 хувь буюу 227.6 тэрбум төгрөгөөр өсч 1292.7 тэрбум төгрөг болжээ.

Гадаад, дотоод цэвэр актив

Монгол улсын хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 41.6 хувь, өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар буурсан бөгөөд -3484.5 тэрбум төгрөг болов. Дотоод цэвэр актив өмнөх сараас 6 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өсч 7703.7 тэрбум төгрөгт хүрэв.

Зураг 7. Гадаад, дотоод цэвэр актив




Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 10 хувь, өмнөх оны мөн үеэс мөн 49.9 хувиар өсч 3526.1 тэрбум төгрөг болжээ. Тайлант сард Төв банк дахь харилцах, хадгаламж 11.2 хувь буюу 270.5 тэрбум төгрөг,

хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 7.8 хувь буюу 40.7 тэрбум төгрөг, банкуудын касс 3.8 хувь буюу 10.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 8. Нөөц мөнгө



Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 8.3 нэгж хувиар өсч 76.3 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 2.4 нэгж хувиар буурч 15.9 хувь, банкуудын кассын эзлэх хувь 5.9 нэгж хувиар буурч 7.8 хувьтай байна.


Зээл

Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлтийн хурд өмнөх сараас 0.9 нэгж хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 7.4 нэгж хувиар буурч жилийн 7.2 хувийн өөрчлөлттэй байна.

Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сарынхаас 1.7 хувь буюу 316.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 7.2 хувь буюу 1245.1 тэрбум төгрөгөөр өсч 18.4 их наяд төгрөг болжээ. Үүний 65.2 хувь буюу 12 их наяд төгрөгийг хадгаламжийн байгууллагуудын, 34.8 хувь буюу 6.4 их наяд төгрөгийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл бүрдүүлж байна.


Санхүүгийн байгууллагуудаас иргэдэд олгосон зээл өмнөх сараас 1.6 хувь буюу 118.1 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 7.4 хувь буюу 519.2 тэрбум төгрөгөөр өсч 7493.6 тэрбум төгрөгт, хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 6.4 хувь буюу 435.1 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 5.3 хувь буюу 366 тэрбум төгрөгөөр өсч 7272.1 тэрбум төгрөг болжээ.

Зураг 9. Зээлийн үлдэгдлийн жилийн өөрчлөлт



Санхүүгийн байгууллагуудын нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 40.7 хувь нь иргэд, 39.5 хувь нь хувийн хэвшил, 19.8 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Зураг 10. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Нийт зээлийн үлдэгдлийн 84.2 хувийг хэвийн зээл, 10.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.6 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 5.4 нэгж хувь, чанаргүй зээлийнх 1.1 нэгж хувиар өссөн байна.

Хадгаламжийн байгууллагуудын зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 8.6 хувь байгаа бөгөөд татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 6.8 хувийг эзэлж байна.

Картын зээл

Банкуудаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон картын зээлийн үлдэгдэл нийт банкны салбарын зээлийн үлдэгдлийн 1.8 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл 6-р сарын байдлаар 209.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар буюу 24.4 тэрбум төгрөгөөр буурчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд өмнөх сараас 1.3 хувиар буюу 0.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 11. Нийт картын зээл болон түүний чанаргүй зээлд эзлэх хувь




Картын зээлийн 90 хувь нь хэвийн, 3.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 6.8 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 93.5 хувь нь төгрөгөөр, 6.5 хувь нь валютаар олгогдсон байна.

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2016 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар бага буюу жилийн 10.51 хувьтай байна. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч жилийн 19.1¹ хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурч жилийн 10.7 хувь болжээ.

Зураг 12. Зээлийн дундаж хүү




Төгрөгийн болон гадаад валютын харилцахын хүү харьцангуй тогтвортой байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсч жилийн 13.3 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд жилийн 6.3 хувьтай байна.

Мөнгөний зах

2016 оны 6 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 793.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 11.3 хувь байна.

Зураг 13. Банк хоорондын захын арилжаанд эзлэх хувийн жин



¹ Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 16.9 хувь байна.


2016 оны 6 сарын 8-ны өдрөөс 2016 оны 6 сарын 21-ний өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 1046.9 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд дунджаар 469.3 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Тодруулбал, банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд дунджаар 1003.4 тэрбум төгрөг, валютын нөөцөд дунджаар 1234.9 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2016 оны 6 дугаар сарын эцэст 1982.25 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.7 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 1964.93 төгрөг байв.

Тайлант сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2201.88, хятадын юаньтай харьцах ханш 298.39, японы иентэй харьцах ханш 19.31 төгрөг болжээ.

Зураг 14. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, 2010.12.31=100




Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2016 оны 6 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.3 хувиар буурч, оны эхнээс 2.9 хувь, өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өссөн бол Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.5 хувиар буурч, оны эхнээс 2.7 хувь, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өсчээ. Суурь инфляци тухайн сард -0.1 хувь, оны эхнээс -1.2, жилийн 3.0 хувьтай байв.

Тухайн сард Улаанбаатар хотын инфляци 0.5 хувиар буурсан нь хүнсний барааны үнэ 1.5 хувь, хүнснээс бусад барааны үнэ 0.1 хувиар буурсантай холбоотой.


Зураг 15. Сарын инфляци



Хүнсний барааны үнийн бууралтанд махны үнэ 4.0 хувиар буурч, жимсний үнэ 2.3 хувь, хүнсний ногооны үнэ 1.8 хувиар өссөн нь нөлөөлжээ. Хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд тамхины үнэ 2.6 хувь, эм, тариа 2.2 хувиар өсч, бензин, дизелийн үнэ 2.1 хувь, хувцас, бөс барааны үнэ 0.6 хувиар буурсан нь нөлөөлөв.

Улаанбаатар хотын **жилийн инфляци** 1.2 хувь байгаа нь хүнсний барааны үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар буурч, хүнснээс бусад барааны үнэ 2.9 хувиар өссөнтэй холбоотой.

Зураг 16. Жилийн инфляци



Хүнсний барааны үнийн өөрчлөлтөд хүнсний ногооны үнэ 9.8 хувь, загас, далайн бүтээгдэхүүний үнэ 7.7 хувь, өөх, тосны үнэ 3.4 хувь, талх, гурил, будааны үнэ 3.0 хувиар өсч, махны үнэ 10.9 хувиар буурсан нь нөлөөлөв. Хүнсний барааны бүлэг жилийн инфляцийн -0.8 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 0.3 хувийг хүнсний ногоо, 0.2 хувийг талх, гурил будаа, -1.4 хувийг махны үнийн өөрчлөлт эзэлжээ.

Хүнснээс бусад барааны жилийн инфляци 2.9 хувь байгаагаас боловсролын бүлгийнх 23.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийнх 9.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 3.2 хувь, гэр ахуйн бараа, тавилгын бүлгийнх 1.9 хувь, зочид буудал, дотуур байрны үйлчилгээний бүлгийнх 1.6 хувиар өсч, тээврийн үнэ 2.1 хувь, орон сууц, цахилгаан, түлшний үнэ 2.0 хувиар буурчээ.

Жилийн инфляцийн 1.7 хувийг боловсролын үйлчилгээ, 0.3 хувийг эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ, 0.1 хувийг хувцас, бөс бараа, 0.1 хувийг гэр ахуйн бараа, тавилга, -0.2 хувийг тээвэр, -0.3 хувийг орон сууц, цахилгаан, түлшний үнийн өөрчлөлт эзэлж байна.